

### **Дэлгэрцогт сумын Залуучуудын чуулга уулзалтын тайлан**

Дэлгэрцогт сумын Залуучуудын чуулган нь 2018 оны 09 сарын 14-ны өдөр “Үндэсний өв соёлоо дээдлэе” уриатайгаар амжилттай зохион байгуулагдлаа. Тус чуулганд Баянбулаг багийн 42, Цахиурт багийн 41, Дэлгэр-Эмт багийн 38, нийт 121 залуус чууллаа.

Залуучуудын чуулганаар хөтөлбөрийн дагуу сумын Засаг дарга Б.Иш-Ёндон 2017-2018 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Мөн чуулганы үеэр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн сургалт, сумын хэсгийн төлөөлөгч Г.Эрдэнэбат “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар сургалт зохион байгууллаа.

“Үндэсний өв соёлоо дээдлэе” чуулганаа Монгол уламжлалт шагайн наадгай, Айрагны баяр, Адууны баяр, сур харваан төрлөөр зохион байгууллаа.





